




**ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

ХЯНАСАН:
ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

(албан тушаал)


.....
(гарын үсэг)

О.ОДБАЯР

ТАЙЛАГНАСАН:
ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

(албан тушаал)


.....
(гарын үсэг)

В.МӨНХЖАРГАЛ

Огноо: 2025 ... оны ¹² дугаар сарын ¹⁸ ны өдөр

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая.төг рөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэл хувь
Зорилго 2: Хот байгуулалт, хот дахин төлөвлөлтийг хөгжүүлэх, салбарын хууль тогтоомж, бодлого, зохицуулалт, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, төлөвлөлт, хөтөлбөр, төсөл боловсруулах, удирдамж, зохицуулалтаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах							
2.1. Хот байгуулалт, хот дахин төлөвлөлтийн салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, хот, тосгон, суурин газрыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зөвөлгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих.							
3.1.22	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна. МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-2.5.2, МУЗГҮАХ/2024-2028/-1.1.3.4, МУЗГҮАХХАХТ-1.1.3.4.40, МУ-ыг хөгжлийн 2025 оны төлөвлөгөө - 2.1.1.9	Барилга байгуул амжийн норм, нормативын сан 50 сая.төг	Ажлын хэсэг-1, Үзэл баримтлалын төсөл-1, Хуулийн төсөл-1 Холбогдох судалгаа-2	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль /2015 он/	-ХББОС-ын сайдын тушаалаар Ажлын хэсгийн бүрэлдэхү үнийг шинэчлэн томилсон байна. -Хуулийн төсөл болон үзэл баримтлалыг боловсруулсан байна. Холбогдох судалгааг хийсэн байна.	ХББОСЯ, Монголын хуульчдын холбоотой хамтран 2025.04.25-ны өдөр зохион байгуулсан “Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хэрэгжилт, хуулийг шинэчлэх судалгааны талаар танилцуулж, оролцогчдоос санал авсан. Мөн ХББОСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний 2025/15 дугаартай ажлын даалгаврыг 2025.09.03-ны өдөр батлуулсан. ББННС-ийн 50.0 сая төгрөгөөр Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төсөл, холбогдох судалгааг хийх ажлыг санхүүжүүлэхээр шийдвэрлүүлж, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирлын 2025 оны а/432 дугаар тушаалаар уг ажлын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулж, “И Эм Эс Консалтинг” ХХК-г шалгаруулж, 2025.10.17-ны өдөр БХТ/20250203297 тоот гэрээ байгуулан ХББОСЯ-аас батлагдсан ажлын даалгаварт заасны дагуу захиалагчийн техник хяналтыг тавьж ажиллаж байна. ХББОС-ын сайдын 2025 оны 221 дүгээр тушаалаар Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох тооцоо, судалгааг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 2025.11.20-ны өдөр зохион байгуулж, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн хэрэгжилтийн байдал болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хот, суурин газрыг дахин	100

						хөгжүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцүүлж, санал авч үзэл баримтлалын төсөлд тусгасан. Мөн Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Зөвлөх багтай хамтран хуулийн төслийн үзэл баримтлалын төслийн эхний хувилбарыг боловсруулан, 2025.11.25-ны өдөр олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, үзэл баримтлалын төслийг хэлэлцүүлж санал авсан. Хэлэлцүүлэгт хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч иргэний төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл нийт 53 хүн оролцож санал солилцлоо. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөлд ажлын хэсгийн гишүүд болон хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг тусган эцэслэн боловсруулсан ба үзэл баримтлалын төслийг энэ ондоо багтаан батлуулахаар ажиллаж байна. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эхний хувилбар, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг боловсруулсан. Хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагын тандан судалгааг хийсэн тайланг боловсруулж байна.	
3.1.29	Аймаг, сумын төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, батлуулах ажлыг орон нутагтай хамтран зохион байгуулна.	Үйл ажиллагаа	Ерөнхий төлөвлөгөө-5-аас доошгүй	21 аймгийн 167 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан.	-Орон нутгийн төсвийн санхүүжилтээр аймаг, сумын төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр болон шинэчлэн боловсруулж, экспертизийн дүгнэлтийг	Улсын хэмжээний 330 сумаас хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй 146 сум, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй 87 сум, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаа 97 сум байна. Боловсруулж байгаа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнөөс 2025 онд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол-5, сумын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө-11, сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-29 нийт улсын хэмжээнд 45 сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулан зөвшилцөн батлуулсан.	100

					гаргуулсан байна.		
3.1.32	БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын техник туслалцааны хүрээнд “Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах, Монгол улсын бүсийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих төсөл”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	КОЙКА-гийн техник туслалцааны санхүүж илтээр	Төслийн судалгааны дундын шатны тайлан-1	Эхлэлийн шатны тайлан	- “Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах, Монгол улсын бүсийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих төсөл”-ийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	1. Тус яамнаас БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах, Монгол улсад бүсийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих төсөл”-ийн зөвлөх баг 2025.03.19-28-ны өдрүүдэд манай улсад ирж холбогдох судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга /2025.30.24/, Хархорум хотын захиргаа /2025.03.20,26/, Хүннү хотын захиргаа /2025.03.25/, НЗДТГ /2025.03.27/, ССАЖЗЯ /2025.03.21/-тай ажлын уулзалтыг тус тус зохион байгуулж, шаардлагатай мэдээллийг бүрдүүлэн авсан. Мөн КОЙКА байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ЗГХЭГ, ССАЖЗЯ-наас холбогдох мэдээллийг гаргуулан авч тус яамны 2025.06.04-ны өдрийн 05/2216 тоот албан бичгээр хүргүүлэв. Төслийн Зөвлөх баг 2025.08.27-оос 09.05-ны Хархорин, Дархан хотуудад ажилласан. Мөн төр захиргааны байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэх асуудалтай холбогдуулан 2025.09.02-ны өдөр ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга У.Бямбасүрэнтэй, автозам, 2025.09.03-ны өдөр ЗТЯ-ны төлөөлөлтэй, 2025.09.04-ний өдөр ХХААҮЯ-ны холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулсан. Мөн 2025.12.01-ний өдөр Боловсролын яам, 2025.12.04-ний өдөр ССАЖЗЯ-ны холбогдох албан тушаалтнуудтай хийх уулзалтыг, 2025.12.02,03-ны өдрүүдэд Хархорум хотын болон Хүннү хотын захиргааны албан тушаалтнуудтай хийх уулзалтыг тус тус зохион байгуулсан. ХББОС-ын сайдын 2025.10.15-ны өдрийн 226 дугаар тушаалаар Төслийн зохицуулах хороог байгуулж, хорооны анхдугаар хурлыг 2025.12.05-ны өдөр зохион байгуулсан. Уг төслийн батлагдсан төлөвлөгөөний дагуу БНСУ-ын төр, захиргааны байгууллага, төрийн албадыг орон нутаг руу шилжүүлсэн бодлого, үйл ажиллагаа, туршлагатай газар дээр нь очиж танилцах сургалтыг 2025.05.18-24-ний өдрүүдэд зохион байгуулж, ЗГХЭГ-ын Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар, ХББОСЯ, ТЕГ-ын төслийн нэгж, Хүннү хотын ЗАА-ны нийт 10 албан хаагч хамрагдсан.	100
3.1.52	“Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл	-	Журмын төсөл-1	Барилга, хот байгуула	Журмын төслийг боловсруу	Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 46 дугаар тушаалаар баталсан “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл болон	100

	ажиллагааны журам"-ын төслийг шинэчлэн боловсруулна.			лтын сайдын 2018 оны 46 дугаар тушаалаар баталсан "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилга жуулах үйл ажиллагааны журам	лж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна.	уг журмын төслийг батлах тухай Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тушаалын төслийг тус тус боловсруулж, ХББОС-ын сайдын 2025 оны 01/1751 дүгээр албан бичгээр нийслэлийн Засаг даргад, 02/2964 дугаар албан бичгээр нийслэл болон аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, 02/2967 дугаар албан бичгээр Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл, ГЗБГЗЗЕГ, ТОСК зэрэг байгууллагад тус тус хүргүүлэн санал авч, журам, тушаалын төслийг эцэслэн боловсруулсан. Мөн нийслэлийн ЗДТГ-аас Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 46 дугаар тушаалаар баталсан "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам"-ыг бүхэлд нь шинэчлэн боловсруулах санал гаргасны дагуу холбогдох саналыг ирүүлэх тухай яамны 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 02/4227 дугаар албан бичгийг нийслэлийн Засаг даргад хүргүүлээд байна.	
3.1.53	"Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын төслийг шинэчлэн боловсруулна.	-	Журмын төсөл-1	Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай	Журмын төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна..	Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар баталсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл болон уг журмын төслийг батлах тухай Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын тушаалын төслийг тус тус боловсруулж, ХББОС-ын сайдын 2025 оны 01/1751 дүгээр албан бичгээр нийслэлийн Засаг даргад, 02/2964 дугаар албан бичгээр нийслэл болон аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, 02/2967 дугаар албан бичгээр Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл, ГЗБГЗЗЕГ, ТОСК зэрэг байгууллагад тус тус хүргүүлэн санал авч, журам, тушаалын төслийг эцэслэн боловсруулсан. Мөн нийслэлийн ЗДТГ-аас Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар баталсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ыг бүхэлд нь шинэчлэн боловсруулах санал гаргасны дагуу холбогдох саналыг ирүүлэх тухай яамны 2025 оны 11 дүгээр	100

				орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”		сарын 14-ний өдрийн 02/4227 дугаар албан бичгийг нийслэлийн Засаг даргад хүргүүлээд байна	
3.1.54	Нийслэл, орон нутагт хот дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлэх, инженерийн шугам сүлжээг төлөвлөн барихад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. МУЗГҮАХХАХТ- 1.1.3.4.	-	Тайлан мэдээ-1	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл - 42 төсөл Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төсөл -28	Нийслэл, орон нутагт хот дахин төлөвлөлтийн төслүүдийн инженерийн шугам сүлжээг төлөвлөн барих үйл ажиллагааны мэдээ, тайланг нэгтгэсэн байна. -Өгөгдөл мэдээллийг бүрдүүлж, хот байгуулалтын кадастрын цахим системд	Улсын хэмжээнд гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүсэд инженерийн дэд бүтэц төлөвлөх ажлын хүрээнд орон нутаг төсөвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 9 төсөл арга хэмжээнүүдийн биелэлтийн тайлан, танилцуулгыг улирал бүр гарган холбогдуулах байгууллага болон Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэн ажилласан. Улсын хэмжээний дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны тайлан, хэрэгжилтийн явцын мэдээллийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 10 дугаар сарын 28-ны өдөр 02/3998, Нийслэлийн холбогдох 3 байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 02/3961 дугаарт албан бичгээр тус тус холбогдох төсөл хэрэгжиж байгаа 11 аймагт Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах төсөл-5, Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах-41, Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих төсөл-17, нийслэлийн Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах-80 хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний 35 төсөл, Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих төсөл-70 төслийн хот дахин төлөвлөлтийн тоон мэдээ мэдээллийг авч хэрэгжилтийн явцыг нэгтгэн дүгнэж Хот суурин газрыг дахин хөгжүүлэх хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсгийн хүрээнд хуулийн төслийн багийг ханд болон газрын удирдлагад 2025 оны 11 дугаар сарын 07-ны өдөр танилцуулж мэдээлэлийг хүргүүлэн ажилласан.	100

					оруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.		
3.1.56	Хот суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны төслүүдийн өгөгдөл мэдээллийг бүрдүүлж, хот байгуулалтын кадастрын цахим системд оруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	-	Үйл ажиллагаа а-1	Мэдээллийн сангийн нэгдсэн системийн үйл ажиллагааны хэрэгжилт -100 хувь	ГЗБГЗЗЕГ мэдээллийн нэгдсэн сан	Хот суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны төслүүдийн өгөгдөл мэдээллийг бүрдүүлж, хот байгуулалтын кадастрын цахим системд оруулах ажлыг мэргэжил арга зүйгээр хангах, цаашид хамтран хэрэгжүүлэх ажлуудын талаар 2025 онд нийт 3 удаа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, санал хүргүүлсэн. Одоо хөгжүүлэлт хийж байгаа гүйцэтгэгч байгууллагын нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд Төлөвлөлтийн баримт бичгийн давхаргад Ерөнхий төлөвлөгөө цэсэд Хот суурин газрыг дахин хөгжүүлэх давхрага нэмэн Нийслэлийн гэр хорооллын 80 хэсэгчилсэн төлөвлөлтийн зураглал оруулсан. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалтай нийслэлийн хэмжээний 378 барилгыг мэдээлэл оруулах эрхийн тохируулга хийх тухай хүсэлтийг ГЗБГЗЗЕГ-т 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр 02/4135 дугаарт албан бичгээр хүргүүлэн өгөгдөл дата мэдээллийг бүрдүүлж байна. Мөн Хот байгуулалтын кадастрын цахим системийн үйл ажиллагаа, хэрэглээнд тулгарч байгаа асуудлын талаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 21 аймгийн Ерөнхий архитекторуудтай цахим хурал зохион байгуулж, цахим системд өгөгдөл мэдээллийг бүрдүүлэх талаар зөвшилцсөн.	100

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ В.МӨНХЖАРГАЛЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Нэгжийн нэр: Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Хот байгуулалтын бодлого, зохицуулалтаар хангах чиглэлээр;					
1.	Арга хэмжээ 1.1 Аймаг, сумын төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, батлуулах ажлыг орон нутагтай хамтран зохион байгуулах	60	10	70	
2.	Арга хэмжээ 1.2 БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын техник туслалцааны хүрээнд "Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах, Монгол улсын бүсийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	60	10	70	
Зорилт 2. Хот суурин газрыг дахин хөгжүүлэх чиглэлээр;					
3.	Арга хэмжээ 2.1 Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт орж, санал өгнө МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-2.5.2, МУЗГҮАХ/2024-2028/-1.1.3.4, МУЗГҮАХХАХТ-1.1.3.4.40, МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө-2.1.1.9	60	10	70	
4.	Арга хэмжээ 2.2 "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам"-ын төслийг шинэчлэн боловсруулах	60	10	70	
5.	Арга хэмжээ 2.3 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын төслийг шинэчлэн боловсруулна.	60	10	70	
6.	Арга хэмжээ 2.4 Нийслэл, орон нутаг хот дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлэх, инженерийн шугам сүлжээг төлөвлөн	60	10	70	

	барихад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах				
7.	Арга хэмжээ 2.5 Хот суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны төслүүдийн өгөгдөл мэдээллийг бүрдүүлж, хот байгуулалтын кадастрын цахим системд оруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	60	10	70	
Зорилт 3. Дотоод үйл ажиллагааг хэвийн хангах;					
8.	Арга хэмжээ 3.1 Удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах	60	10	70	
9.	Арга хэмжээ 3.2 Дотоод ажлын хуваарийн дагуу сайдын шуурхай бусад төлөвлөгөөт ажлыг биелэлтийг гаргаж холбогдох газарт хүргүүлэх	60	10	70	
10.	Арга хэмжээ 3.3 Хариуцсан асуудлаар ажлын хэсэгт орж ажиллах	60	10	70	
11.	Үүрэг даалгавар 1. Салбарын арга хэмжээнд оролцох	60	10	70	
12.	Үүрэг даалгавар 2. Бусад	60	10	70	
Дундаж оноо:					70

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
		1	2	3
1.	Мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах		13	
2.	Холбогдох чиглэлээр судалгаа, танилцуулгын талаар мэдээлэл авах, хамрагдах		13	
Дундаж оноо			13	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
		1	2
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	7	

7.	Мэргэжлийн ур чадвар 2.	7	
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	7	
Дундаж оноо		7	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	РХандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 70
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 13
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(98 оноо) 98
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		98

Үнэлгээ өгсөн:

Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нэгжийн дарга



Ю.Одбаяр/
2025.12.....

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Хот дахин төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Төрийн жинхэнэ албан хаагч:



В.Мөнхжаргал/

2025.12.....

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

..... /

/
2025.12.....

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:
Хүний нөөцийн бодлого, зохицуулалт
хариуцсан ахлах шинжээч


..... /

2025.12.....

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Төрийн нарийн бичгийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч


.....

/М.Баяраа/

2025.12.....